



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/26/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarijargalo@audit.gov.mn](mailto:amarijargalo@audit.gov.mn)

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: [khurelbaatart@audit.gov.mn](mailto:khurelbaatart@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Товчилсон үгийн жагсаалт .....	3
Хүснэгтийн жагсаалт .....	3
<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>4</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b>	<b>6</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>10</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
<b>3.4.1 Мөнгөн хөрөнгө .....</b>	<b>11</b>
<b>3.4.2 Авлага.....</b>	<b>12</b>
<b>3.4.3 Бараа материал .....</b>	<b>12</b>
<b>3.4.4 Үндсэн хөрөнгө .....</b>	<b>13</b>
<b>3.4.5 Өр төлбөр .....</b>	<b>14</b>
<b>3.4.6 Засгийн газрын хувь оролцоо.....</b>	<b>14</b>
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	14
3.5.3 Нэмэлт төсөв .....	15
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат. хүрэх үр дүн .....	16
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>16</b>
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн. өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
5.3 Зөвлөмж .....	Error! Bookmark not defined.
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b>	<b>Error! Bookmark not defined.</b>

## **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар

## **Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.....	11
Хүснэгт 2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл.....	11
Хүснэгт 3 Авлагын үлдэгдэл .....	12
Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл.....	12
Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл .....	13
Хүснэгт 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл.....	14
Хүснэгт 7 Засгийн газрын хувь оролцоо.....	14
Хүснэгт 8 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	15
Хүснэгт 9 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт.....	16
Хүснэгт 10 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	18

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

Ауд. 03.25 № 01/226  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
А.МӨНГӨНБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус сумын 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд 37 хөтөлбөр, 128 арга хэмжээг хэрэгжүүлж 98,0 хувьтай тус тус дүгнэгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,250,000.0 мянган төгрөгөөр 15 ортой эрүүл мэндийн төвийн барилгын ажил, "Сумын хөгжил-инженерийн дэд бүтэц" 1,850,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр 2 дахь жилдээ, сумын төвийн хатуу хучилттай авто зам 1,533,100.0 мянган төгрөгөөр, зам дагуу 73 ширхэг гэрэлтүүлэг гэх мэт хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

G/Архив/Албан бичиг 2024/ А4

010920578

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,418,797.20	1,935,406.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,618,074.93	987,531.07
33	АВЛАГА	537,561.34	455,381.88
35	БАРАА МАТЕРИАЛ	263,160.93	492,493.35
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,578,761.39	3,666,020.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,578,761.39	3,666,020.47
39200	Биет хөрөнгө	1,564,965.02	3,652,673.97
39300	Биет бус хөрөнгө	13,796.38	13,346.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,997,558.59	5,601,426.78
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,687.34	374,128.86
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,687.34	374,128.86
41300	Өглөг	12,687.34	374,128.86
41360	Бусад өглөг	12,687.34	972.48
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,984,871.25	5,227,297.92
51	Засгийн газрын хувь оролцоо	3,984,871.25	5,227,297.92
51200	Хуримтлагдсан үр дүн	3,306,091.96	4,548,518.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,997,558.59	5,601,426.78

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,987,492.93	3,774,080.37
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,069,842.15	1,947,906.32
110	Орлогын албан татвар	491,703.34	880,559.99
1100	Хувь хүний орлогын албан татвар	502,223.52	892,559.99
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-10,520.18	-12,000.00
113	Хөрөнгийн албан татвар	108,328.02	212,902.61
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,469,810.79	854,443.73
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	24,417.09	39,223.06
1181	Газрын төлбөр	373,568.89	595,744.78
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,071,824.80	219,475.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	584,516.36	870,185.26
120	Нийтлэг татварын бус орлого	584,516.36	870,185.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	136,068.71	99,475.94
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,333,134.43	955,988.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	349,262.30	601,508.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	372,252.69	354,479.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,611,619.44	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,774,864.86	2,019,435.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,774,864.86	2,019,435.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,610,200.47	1,976,572.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	401,897.87	551,182.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,843.37	67,202.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	643,297.35	118,348.78
2104	Хангамж, бараа материалын зардал	94,455.75	107,056.54
2105	Нормативт зардал	0.00	600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,044.00	28,566.00
2107	Томиллот, зочны зардал	9,603.20	7,498.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,744.55	59,493.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	340,314.38	1,036,625.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,164,664.39	42,862.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,321.34	2,839.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,103,343.04	40,023.79
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,212,628.07	1,754,644.87
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,302,498.26	512,218.21
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	910,129.82	1,242,426.66

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,823,378.43	3,572,720.48
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,069,842.15	1,947,906.32
110	Орлогын албан татвар	491,703.34	880,559.99
1100	Хувь хүний орлогын албан татвар	502,223.52	892,559.99
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-10,520.18	-12,000.00
113	Хөрөнгийн албан татвар	108,328.02	212,902.61
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,469,810.79	854,443.73
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	24,417.09	39,223.06
1181	Газрын төлбөр	373,568.89	595,744.78
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,071,824.80	219,475.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	420,401.86	668,825.36
120	Нийтлэг татварын бус орлого	420,401.86	668,825.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	204,444.19	148,655.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,333,134.43	955,988.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	349,262.30	601,508.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	372,252.69	354,479.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,611,619.44	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,770,448.50	1,847,552.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,770,448.50	1,847,552.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,597,115.83	1,804,689.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,497.87	550,582.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,843.37	67,202.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	643,759.89	118,348.78
2104	Хангамж, бараа материалын зардал	205,931.59	198,085.93
2105	Нормативт зардал	0.00	600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,044.00	28,566.00
2107	Томилолт, зочны зардал	9,603.20	7,498.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,143.74	59,514.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	209,292.16	774,291.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,173,332.67	42,862.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,321.34	2,839.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,103,343.04	40,023.79
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,668.28	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,052,929.93	1,725,168.29

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	814,644.50	2,295,342.16
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	814,644.50	2,295,342.16
2200	Дотоод эх үүсвэрээр	814,644.50	2,295,342.16
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-814,644.50	-2,295,342.16
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-80,596.00	-60,370.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	80,596.00	60,370.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,157,689.43	-630,543.86

#### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,276,153.70	941,161.37	5,894,041.14	9,111,356.21
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,742,141.83	-796,393.95	-3,498,079.00	-6,036,614.78
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	534,011.87	144,767.42	2,395,962.15	3,074,741.44
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	910,129.82	910,129.82
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	534,011.87	144,767.42	3,306,091.96	3,984,871.25
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	534,011.87	144,767.42	3,306,091.96	3,984,871.25
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	534,011.87	144,767.42	3,306,091.96	3,984,871.25
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,242,426.66	1,242,426.66
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	534,011.87	144,767.42	4,548,518.63	5,227,297.92

#### 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,103,036.50	3,537,917.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,778,589.70	1,591,905.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,774,589.70	1,589,066.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	508,489.90	505,797.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,561.10	62,846.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	756,861.30	709,389.73
2104	Хангамж, бараа материалын зардал	84,852.40	79,901.24
2105	Нормативт зардал	1,000.00	600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,750.00	18,374.50

2107	Томиллолт, зочны зардал	10,642.00	7,498.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,398.00	26,707.88
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	302,035.00	177,951.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,000.00	2,839.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000.00	2,839.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,222,896.80	1,885,642.16
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	101,550.00	60,370.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,103,036.50	3,630,045.37
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	616,953.70	601,508.90
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,911,289.70	2,961,916.41
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,574,793.10	66,620.06
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	62	62
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30	30
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	30	30

## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	372,289.69	464,416.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	172,289.69	104,416.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,360.99	82,682.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,719.20	34,397.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	339.90	4,355.80
2104	Хангамж, бараа материалын зардал	1,944.00	75.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500.00	1,229.72
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,857.89	42,624.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,928.70	21,734.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,945.10	0.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	104,983.60	21,734.54
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	200,000.00	360,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	200,000.00	360,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	372,252.69	464,416.88
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	372,252.69	464,416.88
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-37.00	0.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,250,000.0 мянган төгрөгөөр 15 ортой эрүүл мэндийн төвийн барилгын ажил, “Сумын хөгжил-инженерийн дэд бүтэц” 1,850,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр 2 дахь жилдээ, сумын төвийн хатуу хучилттай авто зам 1,533,100.0 мянган төгрөгөөр, зам дагуу 73 ширхэг гэрэлтүүлэг гэх мэт хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн байна.

Тус сумын 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд 37 хөтөлбөр, 128 арга хэмжээг хэрэгжүүлж 98,0 хувьтай тус тус дүгнэгдсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Эрдэнэ сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод хяналтын төлөвлөгөөг 2023 онд нийт 6 чиглэлээр 9 ажил үүрэг гүйцэтгэхээр төлөвлөн батлуулан ажиллаж зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд 2021 онд батлагдсан 6 бүлэг, 56 зүйл бүхий нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 5,601,426.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,603,868.1 мянган төгрөгөөр буюу 40,1 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	1,618,074.93	987,531.07	-630,543.86
Авлага	537,561.34	455,381.88	-82,179.46
Бараа материал	263,160.93	492,493.35	229,332.42
Үндсэн хөрөнгө	1,578,761.39	3,666,020.47	2,087,259.08
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,997,558.59</b>	<b>5,601,426.78</b>	<b>1,603,868.18</b>
Өр төлбөр	12,687.34	374,128.86	361,441.52
Засгийн газрын хуьт оролцоо /Эздийн өмч/	3,984,871.25	5,227,297.92	1,242,426.66
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө / өмчийн дү</b>	<b>3,997,558.59</b>	<b>5,601,426.78</b>	<b>1,603,868.18</b>

*Эх сурвалж: Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 987,531.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 630,543.8 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын дансны эцсийн үлдэгдэл 741,277.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 723,264.9 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 455,381.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 82,179.4 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн хөгжлийн сангийн авлага 58,316.4 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын авлага 36,670.2 мянган төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 492,493.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 229,332.4 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын бараа материал 237,790.6 мянган төгрөгөөр, ИТХ-ын бараа материал 70.4 мянган төгрөгөөр, Эрдэнэ тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын бараа материал 672.2 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 3,666,020.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,087,259.0 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын үндсэн хөрөнгө 2,087,515.0 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 374,128.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 361,441.5 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын өр төлбөр 373,156.3 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 5,227,297.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,242,426.6 мянган төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагуудын үр дүнгээс шалтгаалсан байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,618,074.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 630,543.8 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>1,618,074.93</b>	<b>1,618,074.93</b>	<b>0.00</b>
<b>Төгрөг</b>	<b>1,618,074.93</b>	<b>1,618,074.93</b>	<b>0.00</b>
Төрийн сангийн харилцах	1,616,884.74	985,747.68	-631,137.06
Арилжааны банк дахь харилцах	1,190.19	1,783.39	593.20
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	0.00	0.00
<b>Дүн</b>	<b>1,618,074.93</b>	<b>987,531.07</b>	<b>-630,543.87</b>

Эх сурвалж: Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 1,618,074.9 мянган төгрөгийн 75,2 хувь буюу 741,277.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 21,7 хувь буюу 213,923.3 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 3,0 хувь буюу 30,546.4 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл тус тус байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 987,531.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 630,543.8 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын дансны эцсийн үлдэгдэл 741,277.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 723,264.9 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 455,381.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 82,179.4 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 3 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-	0.00
Байгууллагаас авах авлага	216,373.92	119,835.31	-96,538.61
Хувь хүмүүсээс авах авлага	321,187.42	335,546.57	14,359.15
<b>Дүн</b>	<b>537,561.34</b>	<b>455,381.88</b>	<b>-82,179.46</b>

Эх сурвалж: Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын жилийн эцсийн үлдэгдэл 455,381.8 мянган төгрөгийн 76,2 хувийг хувь буюу 347,116.2 мянган төгрөгийг хүмүүсээс авах авлага эзэлж байна. Энэ нь хоршоо хөгжүүлэх сангийн авлага байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 455,381.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 82,179.4 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн хөгжлийн сангийн авлага 58,316.4 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын авлага 36,670.2 мянган төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалсан байна.

#### Аудитын илрүүлэлт

ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар:

- Цалингийн урьдчилгаа 77,400.0 мянган төгрөгийг авлагын дансанд бүртгэлгүй шууд зардалд хааж бичсэн алдааг аудитын явцад залруулсан.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 492,493.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 229,332.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 492,493.3 мянган төгрөгийн 437,993.7 мянган төгрөг буюу 88,9 хувийг ЗДТГ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 492,493.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 229,332.4 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын бараа материал 237,790.6 мянган төгрөгөөр, ИТХ-ын бараа материал 70.4 мянган төгрөгөөр, Эрдэнэ тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын бараа материал 672.2 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

**Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл**

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>92,544.35</b>	<b>83,343.41</b>	<b>-9,200.94</b>
Тусгай зориулалттай материал	25,976.04	25,976.04	0.00
Эм боох материал	55,495.84	46,294.90	-9,200.94
Бэлэн бүтээгдэхүүн	11,072.47	11,072.47	0.00
<b>Хангамжийн материал</b>	<b>133,559.92</b>	<b>382,544.27</b>	<b>248,984.35</b>
Бичиг хэргийн материал	248.00	564.80	316.80
Аж ахуйн материал	15,614.76	15,614.76	0.00
Сэлбэг хэрэгсэл	5,281.30	5,281.30	0.00
Түлш, шатах тослох материал	-	672.26	672.26
Барилгын засварын материал	-	-	0.00
Хүнсний материал	-	-	0.00
Бусад хангамжийн материал	112,415.86	360,411.15	247,995.29
Мал амьтад	37,056.67	26,605.66	-10,451.01
<b>Дүн</b>	<b>263,160.93</b>	<b>492,493.34</b>	<b>229,332.41</b>

Эх сурвалж: Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.4.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 4,829,996.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,240,940.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн 3,666,020.4 мянган төгрөгийн үлдэгдлийн 99,4 хувь буюу 3,643,438.1 мянган төгрөгийг сумын ЗДТГ, үлдэх хувийг эмийн эргэлтийн сан, ИТХ, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө эзэлж байна.

**Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл**

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>2,572,649.46</b>	<b>4,814,074.95</b>	<b>2,241,425.49</b>
Барилга, байгууламж, орон сууц	1,336,761.30	1,393,322.77	56,561.47
Авто тээврийн хэрэгсэл	360,099.51	453,074.61	92,975.10
Машин тоног төхөөрөмж	411,311.96	478,438.13	67,126.17
Тавилга, аж ахуйн эд хогшил	51,766.30	42,254.93	-9,511.37
Зам, гүүрийн байгууламж	64,200.00	1,585,157.27	1,520,957.27
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,610.80	10,610.80	0.00
Бусад үндсэн хөрөнгө	337,899.59	851,216.44	513,316.85
Номын фонд	-	-	0.00
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>16,406.50</b>	<b>15,921.50</b>	<b>-485.00</b>
Программ хангамж	4,672.50	4,187.50	-485.00
Бусад биет бус хөрөнгө	11,734.00	11,734.00	0.00
<b>Дүн</b>	<b>2,589,055.96</b>	<b>4,829,996.45</b>	<b>2,240,940.49</b>

Эх сурвалж: Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 3,666,020.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,087,259.0 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын үндсэн хөрөнгө 2,087,515.0 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

**Аудитын илрүүлэлт**

ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар:

- Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд 5,049.7 мянган төгрөгийн элэгдэл бодогдоогүй алдааг аудитын явцад залруулсан.
- Нуурын эргийн тохижилтоор тарьсан 20,000.0 мянган төгрөгийн модыг үнэлж санхүүгийн тайланд тусгаагүй байна.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 374,128.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 361,441.5 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний бусад зардлын өглөг		373,156.38	373,156.38
Байгууллагад төлөх өглөг	12,478.71	785.00	-11,693.71
Хувь хүмүүст төлөх өглөг	118.20	118.20	0.00
Татварын өглөг /ТӨҮГ/	90.43	69.28	-21.15
<b>Дүн</b>	<b>12,687.34</b>	<b>374,128.86</b>	<b>361,441.52</b>

Эх сурвалж: Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 361,441.5 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн 374,128.8 мянган төгрөгийн үлдэгдлийн 99,7 хувь буюу 373,156.3 мянган төгрөг нь ЗДТГ-ын өглөг байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,227,297.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,242,526.6 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 7 Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал / Засгийн газрын сан / орон нутгийн сан	533,911.87	534,011.87	100.00
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>3,450,859.39</b>	<b>4,693,286.04</b>	1,242,426.66
Өмнөх үеийн үр дүн	2,213,747.78	3,306,091.96	1,092,344.18
Тайлант үеийн үр дүн	1,092,344.19	1,242,426.66	150,082.47
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	144,767.42	144,767.42	0.00
<b>Дүн</b>	<b>3,984,771.25</b>	<b>5,227,297.91</b>	<b>1,242,526.66</b>

Эх сурвалж: Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 1,242,526.6 мянган төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагуудын үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Эрдэнэ сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 120,7430.6 мянган төгрөг, 2023 оны төсвийн жилийн урсгал үйл ажиллагааны зардлыг 2,649,137.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 884,667.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,092,097.6 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны зардлыг 475,500.0 мянган төгрөгөөр бууруулан 2,173,637.1 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 101,505.0 мянган төгрөгөөр, 2022 оны шилжих хөрөнгө оруулалтын хөрөнгийн зардалд 1,292,800.0 мянган төгрөг, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 765,161.5 мянган төгрөгөөр, нийт 4,231,598.6 мянган төгрөгийг сумын

ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн “2023 оны төсөв батлах тухай” 73 дугаар тогтоолоор баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 141240.8 мянган төгрөгөөр хасаж 1,950,856.8 мянган төгрөгөөр, нийт урсгал үйл ажиллагааны зардлыг 190,545.0 мянган төгрөгөөр хасаж 4,041,053.6 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 101,505.0 мянган төгрөгөөр, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 889,096.8 мянган төгрөгөөр, нийт 4,041,053.6 мянган төгрөгийг сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 15 -ны өдрийн “Сумын 2023 оны төсөвт тодотгол батлах тухай” 22 дугаар тогтоолоор тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 1,950,856.8 мянган төгрөг, орон нутгаас аймгийн төсвийн орлогод 39567.1 мянган төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 616,953.7 мянган төгрөг, ОНХС-ийн шилжих үлдэгдлээс 180,443.1 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 1,292,800.0 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 101,550.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,221,751.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 259,835.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,537,917.5 мянган төгрөг буюу 86,2 хувьтай байгаа нь орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл 66,6 хувьтай, хоршоо хөгжүүлэх сангийн гүйцэтгэл 59,4 хувьтай байгаатай холбоотой байна.

### Хүснэгт 8 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01-2023.12.31	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	97%	139,500.10	135,203.90
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	92%	2,334,932.20	2,158,935.30
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01-2023.12.31	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	59%	101,550.00	60,370.00
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	100%	419,579.80	419,568.50
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	99%	84,465.20	83,914.30
6	71702-Соёлын үйлчилгээ	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	95%	67,510.30	64126.2
7	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	48%	66,402.10	31,806.50
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01-2023.12.31	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	66%	889,096.80	583,992.90

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 453,497.4 мянган төгрөг, ИТХ нь 10,919.4 мянган төгрөг нийт 464,416.8 мянган төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого. зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат. хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

#### Хүснэгт 9 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн хөгжлийн сан - хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	889,096.80	583,992.90	305,103.90	65.68%
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага - үндсэн үйл ажиллагааны зардал	2,334,932.20	2,158,935.30	175,996.90	92.46%
3	Хоршоо хөгжүүлэх сан - үндсэн үйл ажиллагааны зардал	101,550.00	60,370.00	41,180.00	59.45%
4	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага - үндсэн үйл ажиллагааны зардал	139,500.10	135,203.90	4,296.20	96.92%
5	Ерөнхий боловсролын сургууль - тогтмол зардал	419,579.80	419,568.50	11.30	100.00%
6	Сургуулийн өмнөх боловсрол - тогтмол зардал	84,465.20	83,914.30	550.90	99.35%
7	Эрүүл мэндийн төв - тогтмол зардал	66,402.10	31,806.50	34,595.60	47.90%
8	Соёлын үйлчилгээ - тогтмол зардал	67,510.30	64126.2	3,384.10	94.99%
		<b>4,103,036.50</b>	<b>3,537,917.60</b>	<b>565,118.90</b>	<b>86.23%</b>

Тус сум нь тайлант онд нийт 2,415,885.3 мянган төгрөгийн 18 тендерийг зарлаж, сонгон шалгаруулалтыг явуулсан байна. Мөн ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрээс худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт. зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан. төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага. түүний орчин. аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал. дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт. дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж. хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга. тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан. төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/72 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож. материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн суурь үзүүлэлтийг нийт орлого 3,862,249.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 57,933.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 43,450.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга. нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих мэдээлбэл зохих 171 мэдээллээс хугацаа хоцроосон 7 мэдээлэл, мэдээлээгүй мэдээлэл байхгүй байна.

### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## **4.5 Завсрын аудитын үр дүн. өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагааанд 2023 оны гуравдугаар улирлын байдлаар завсрын аудитыг хийж 2 зөвлөмж өгсөн байна.

### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 01/159 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

**Хүснэгт 10 Төлбөрийн акт. албан шаардлага. зөвлөмжийн хэрэгжилт**

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	108,120.9	2	108,120.9	100%
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>108,120.9</b>	<b>2</b>	<b>108,120.9</b>	<b>100%</b>

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар ОНХС-ийн иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, зарцуулалттай холбоотой асуудлыг гүйцэтгэлийн аудитаар авч үзнэ.

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

**Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.**

**6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
4	Эмийн эргэлтийн сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>4</b>		<b>1</b>			

## 7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ										
ЗДТГ	2	82,449.7	1	5,049.7	1	77,400.0	2	82,449.7		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>82,449.7</b>	<b>1</b>	<b>5,049.7</b>	<b>1</b>	<b>77,400.0</b>	<b>2</b>	<b>82,449.7</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга								
ИТХ	1	2,525.3	1	2,525.3				
ЗДТГ	2	7,068.8	1	12,787.3	1	2,125.3	1	20,000.0
Эргэлтийн эмийн сан	3	9,596.5	2	690.0	1	8,906.5		
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>19,190.6</b>	<b>4</b>	<b>16,002.6</b>	<b>2</b>	<b>11,031.8</b>	<b>1</b>	<b>20,000.0</b>